

Засгийн газрын 2025 оны 06 дугаар
сарын 25-ны өдрийн 07 дугаар
тогтоолын 12 дугаар хавсралт

СОЁЛ, СПОРТ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, ЗАЛУУЧУУДЫН ЯАМНЫ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТРАТЕГИ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН
БҮТЦИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ХӨТӨЛБӨР

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Оршил

Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам (цаашид “Яам” гэх)-ны үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр (цаашид “Хөтөлбөр” гэх)-ийн зорилго нь Засгийн газрын болон Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд (цаашид “Сайд” гэх)-ын эрхлэх асуудлын хүрээнд хууль тогтоомж, салбарын хөгжлийн стратеги, бодлогын үндсэн чиглэлийг тодорхойлох, бодлогын удирдамжаар хангах, төрийн захиргааны удирдлагаар хангах, бодлогын хэрэгжилтийг зохицуулах, хэрэгжилтэд хяналт-үнэлгээ хийж, тайлагнах, асуудлыг хамарсан үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн нэгж, тэдгээрийн үндсэн үүрэг, чиг үүргийг тодорхойлоход оршино.

1.2.Үндэслэл

Энэ хөтөлбөрийг боловсруулахдаа Монгол Улсын Засгийн газрын тухай хууль, Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хууль, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийг тус тус үндэслэл болгов.

1.3. Хууль, эрх зүйн орчин:

Хөтөлбөрийг дор дурдсан хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлнэ:

-Монгол Улсын Үндсэн хууль;

-Монгол Улсын Засгийн газрын тухай хууль;

-Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хууль;

-Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль;

-Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль;

-Хууль тогтоомжийн тухай хууль;

-Төсвийн тухай хууль;

-Төрийн албаны тухай хууль;

- Захиргааны ерөнхий хууль;
- Соёлын тухай (шинэчилсэн найруулга) хууль;
- Соёлын өвийг хамгаалах тухай хууль;
- Номын сангийн тухай хууль;
- Кино урлагийг дэмжих тухай хууль;
- Музейн тухай хууль;
- Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль;
- Биеийн тамир, спортын тухай хууль;
- Аялал жуулчлалын тухай хууль;
- Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль;
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль;
- Олон улсын гэрээний тухай хууль;
- Инновацийн тухай хууль;
- Оюуны өмчийн тухай хууль;
- Зохиогчийн эрхийн тухай хууль;
- Монгол хэлний тухай хууль;
- Үндэсний их баяр наадмын тухай хууль;
- Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль;
- Төрийн хяналт шалгалтын тухай хууль;
- Зөрчлийн тухай хууль;
- Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль;
- холбогдох бусад хууль тогтоомж.

1.4.Арга зүй

Хөтөлбөрийг боловсруулахад хууль, эрх зүйн орчны өөрчлөлт, засаглал болон өөрчлөлтийн удирдлага, байгууллагын өөрчлөлтийн онол, арга зүй, олон улсын жишиг, өмнөх хөтөлбөрүүдийн ололт, сургамжид үндэслэн нийтлэг арга зүйг ашиглалаа. Мөн салбарын өмнө тулгамдаж байгаа асуудал, тэргүүлэх чиглэл, стратегийн зорилт, үйл ажиллагааны гол зорилт, зохион байгуулалтын бүтцийн нэгжүүдийн үндсэн үүрэг, чиг үүргийг тодорхойлох арга зүйг ашиглав.

1.5. Яамны үүрэг, хариуцлагын хуваарь

Яам нь соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын хөгжлийн талаарх хууль тогтоомж, бодлого, стратегийг тодорхойлох, хэрэгжүүлэх, хяналт тавих үүрэг, хариуцлага хүлээж, сайд болон Засгийн газарт мэргэжлийн зөвлөгөө, бүх талын дэмжлэг үзүүлнэ. Хариуцсан чиг үүргийн дагуу иргэдэд шуурхай, мэргэжлийн үйлчилгээ үзүүлнэ.

1.6. Стратегийн удирдлага зохицуулалтын, хэрэгцээний эх үүсвэр

Яамны стратегийн удирдлага, зохицуулалтын хэрэгцээний эх үүсвэр, нэн ялангуяа үндсэн үйлчлүүлэгч буюу хэрэглэгчийг оновчтой, бүрэн тодорхойлох нь яамны үйл ажиллагааны стратегийг тодорхойлоход чухал ач холбогдолтойг харгалзан энэ хэрэгцээний эх үүсвэрт дараах үйлчлүүлэгч буюу хэрэглэгчийг хамруулав.

Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны стратеги
удирдлага, зохицуулалтын хэрэгцээний эх үүсвэр



Яамны үндсэн үйлчлүүлэгч буюу хэрэглэгч нь сайд, Засгийн газар (танхим) болно. Стратегийн удирдлага, зохицуулалт нь дээр дурдсан хэрэгцээний эх үүсвэр, үндсэн үйлчлүүлэгч буюу хэрэглэгчийн эрэлт хэрэгцээг хангахтай холбогдон үүсэх харилцааг зохицуулахад чиглэнэ.

Яамны стратегийн удирдлага, зохицуулалтын хэрэгцээг хангах үйлчилгээний хүрээ, төрөл, хэлбэрийг хэрэгцээний эх үүсвэр тус бүрээр тогтоон тус яамны зохион байгуулалтын бүтцийн нэгжүүдийн үйл ажиллагааны стратеги, албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтод нарийвчлан тусгаж хэрэгжүүлнэ.

Хоёр.Яамны үйл ажиллагааны стратеги

2.1.Яамны үйл ажиллагааны стратегийн мөн чанар

Яамны үйл ажиллагааны стратегийн мөн чанар нь хууль тогтоомж, хөгжлийн бодлогын баримт бичиг, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, улсын хөгжлийн төлөвлөгөө, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын эрхлэх асуудлын хүрээний бодлогыг төлөвлөх, зохицуулах, дүн шинжилгээ хийх, үнэлгээ өгөх, яамны зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд, харьяа агентлагийн үйл ажиллагааг шуурхай зохицуулах чиг үүргийг хэрэгжүүлэхэд чиглэгдэнэ.

2.2.Яамны үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл

Яам дараах үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлтэй ажиллана:

2.2.1.соёл, спорт, аялал жуулчлалыг хөгжүүлэх, залуучуудын хөгжил, оролцоог дэмжих нэгдсэн бодлого тодорхойлох;

2.2.2.эрхлэх асуудлын хүрээний салбарын цахим хөгжлийн бодлого төлөвлөлтийг тодорхойлж, мэдээллийн тогтолцоог бүрдүүлж, дижитал шилжилтийг эрчимжүүлэх;

2.2.3.иргэдийн соёлын боловсролыг дээшлүүлэх, олон нийт, нийгмийг соён гэгээрүүлэх;

2.2.4.соёл, урлагийг хөгжүүлж, олон улсад өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, соёлын бүтээлч үйлдвэрлэлийг эдийн засгийн бие даасан салбар болгох;

2.2.5.соёлын өвийн хамгаалах, хөгжүүлэх, үнэ цэнэт байдлыг нэмэгдүүлэх;

2.2.6.иргэдийн бие бялдрын боловсролыг дээшлүүлэх, биеийн тамир, спортыг хөгжүүлэх, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх;

2.2.7.тогтвортой хөгжлийг дэмжсэн дөрвөн улирлын аялал жуулчлалыг хөгжүүлэх, дэд бүтцийн чанар, хүртээмжийг сайжруулж, нийгэм, эдийн засагт оруулах хувь нэмрийг нэмэгдүүлэх;

2.2.8.залуучуудын хөгжил, оролцоог дэмжиж, үнэлэмжийг нэмэгдүүлэх;

2.2.9.соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын хөгжлийн чиглэлээр оновчтой тогтолцоо, бүтцийг бий болгож, салбарын бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах, олон талт, хүртээмжтэй үйлчилгээ үзүүлэх, хяналт тавих;

2.2.10.эрхлэх асуудлын хүрээний статистикийн мэдээллийг боловсронгуй болгох, дүн шинжилгээ хийх, салбарын нэгдсэн судалгаа, мэдээллийн сан бүрдүүлэх;

2.2.11.төр, хувийн хэвшилд түншлэл бүхий тогтолцоог хөгжүүлэх, бэхжүүлэх, сайдын эрхлэх асуудлын хүрээнд гад аад хамтын ажиллагааг өргөжүүлэх, мэдээлэл сурталчилгааг хэрэгжүүлэх.

2.3.Яамны үйл ажиллагааны эрхэм зорилго

Яамны эрхэм зорилго нь соёлын өв, үндэсний уламжлалыг өвлөн уламжилсан, соёлын болон бие бялдрын боловсролтой өв тэгш монгол хүнийг төлөвшүүлж, залуучуудын үнэлэмжийн нэмэгдүүлэн, уламжлал, шинэчлэлийг хослуулан соёл, урлаг, спортын олон улсад өрсөлдөх нөхцөлийг сайжруулж, байгальд ээлтэй тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх замаар эх орноо хайрлах үзэл ухамсрыг төлөвшүүлэн түгээж, үндэсний нэгдмэл үнэт зүйлийг нэмэгдүүлэх, тогтвортой хөгжлийг хангахад оршино.

2.4.Үйл ажиллагааны стратегийн зорилт

Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам нь үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл, эрхэм зорилгынхоо хүрээнд дор дурдсан үйл ажиллагааны стратегийн зорилтыг хэрэгжүүлнэ:

2.4.1.эрхлэх асуудлын хүрээнд хамаарах бодлогын судалгаа, төсвийн шинжилгээ хийж, салбар хоорондын уялдааг хангаж, нэгдсэн бодлогыг тодорхойлох, хууль тогтоомж, дүрэм, журам боловсруулах, статистик мэдээлэл боловсруулах, дүн шинжилгээ хийх, мэдээллийн сан бүрдүүлэх, салбарын бодлого төлөвлөлтийг инновац, мэдээллийн технологиор дэмжих, цахим шилжилтийн бодлого, төр хувийн хэвшлийн түншлэл, хамтын ажиллагааны хүрээнд хөтөлбөр, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх ажлыг салбарын хэмжээнд нэгдсэн бодлого, удирдлага, зохицуулалтаар хангах;

2.4.2.төрийн захиргааны удирдлага, зохион байгуулалтыг хэрэгжүүлэх, салбарын хүний нөөц, сургалт, нийгмийн баталгааны төлөвлөлтийг хийж, байгууллагын соёлыг төлөвшүүлэх, эрх зүйн дэмжлэг үзүүлэх;

2.4.3.бүх нийтийн соёлын боловсролын үйл ажиллагааг хэрэгжүүлж, үндэсний, сонгодог, орчин үеийн урлагийн төрлүүдийг хөгжүүлэх, үндэсний болон олон улсын хэмжээнд өрсөлдөхүйц түвшинд хүргэх, соёлын үйлчилгээг тэгш, хүртээмжтэй (чанартай) хүргэх үйл ажиллагааг зохион байгуулах;

2.4.4.соёлын өвийг бүртгэн баримтжуулах, судлан шинжлэх, хадгалж, хамгаалах, сэргээн засварлах, түгээн дэлгэрүүлэх, сурталчлах, зохистой ашиглах үйл ажиллагааг зохион байгуулах;

2.4.5.иргэний бие бялдрын боловсролыг дээшлүүлэх, спортын төрлийг хөгжүүлэх, биеийн тамир, спортоор хичээллэх орчин, нөхцөлийг сайжруулж, хүртээмжийг нэмэгдүүлэх, шигшээ багийн тамирчдыг бэлтгэх тогтолцоог бэхжүүлж, тамирчдын тив, дэлхий, олимпын түвшинд өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, үндэсний болон мэргэжлийн спортыг дэмжих ажлыг зохион байгуулах;

2.4.6.аялал жуулчлалын чөлөөт бүс, бүтээгдэхүүн, үйлчилгээ, дэд бүтцийг хөгжүүлэх, байгаль, түүх, соёлын өвийн нөөцөд тулгуурласан соёлын бүтээгдэхүүн, контентыг өргөжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах;

2.4.7.залуучуудын хөгжил, оролцоог дэмжих үйл ажиллагааг зохион байгуулах, зохицуулах, залуучуудын хувь хүний хөгжил болон нийгэм, эдийн

засгийн хөгжилд хувь нэмрээ оруулахад шаардлагатай бүх төрлийн дэмжлэг, туслалцааг үзүүлэх, орчин, нөхцөл бүрдүүлэх;

2.4.8.эрхлэх асуудлын хүрээний гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх, олон улстай хамтран ажиллах;

2.4.9.төсвийн ерөнхийлөн захирагчийн төсөв, хөрөнгө оруулалтыг төлөвлөх, хөтөлбөр, төслийн хэрэгжилтийг зохицуулах, санхүүгийн үйл ажиллагааг зохион байгуулах, төрийн сангийн үйл ажиллагааг эрхлэх;

2.4.10.бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилт, сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ, хяналт шалгалт, дотоод аудит хийж, эрсдэлийн түвшнийг тогтоох, бууруулах, дүгнэлт, зөвлөмж өгч, хэрэгжилтийг хангуулах, үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх.

2.5.Яамны үйл ажиллагааны гол зорилт

Стратегийн зорилтын хүрээнд дор дурдсан үйл ажиллагааны гол зорилтыг хэрэгжүүлнэ:

2.5.1.Үйл ажиллагааны стратегийн 1 дүгээр зорилтын хүрээнд:

2.5.1.1.эрхлэх асуудлын хүрээний тэргүүлэх чиглэл, нэгдсэн бодлогыг тодорхойлж, төлөвлөлтийг боловсруулах, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, хэрэгжилтийг бодлогын нэгдсэн арга зүйгээр дэмжиж, салбар дундын уялдааг хангах, салбарын нэгдсэн тайланд дүн шинжилгээ хийх;

2.5.1.2.эрхлэх асуудлын хүрээний салбарын эдийн засаг, санхүү, цалин хөлс, гадаадын зээл, тусламж, төр, хувийн хэвшлийн түншлэлийн бодлогыг боловсруулах, төлөвлөх;

2.5.1.3.эрхлэх асуудлын хүрээнд судалгаа, эрдэм шинжилгээний тэргүүлэх чиглэлийг салбарын бодлогод нийцүүлэн боловсруулах, төлөвлөх, үр дүнг практикт нэвтрүүлэх ажлыг нэгдсэн удирдлагаар хангах;

2.5.1.4.эрхлэх асуудлын хүрээний статистикийн мэдээллийг олон улсын аргачлалтай уялдуулах, нэгтгэх, боловсруулах, дүн шинжилгээ хийх, мэдээллийн сан бүрдүүлэх, хэрэглэгчийг мэдээллээр хангах;

2.5.1.5.эрхлэх асуудлын хүрээний удирдлагын мэдээллийн тогтолцоог бүрдүүлэх, салбарын бодлогыг инноваци, мэдээллийн технологиор дэмжих, үйл ажиллагааг цахимжуулах, төрийн цахим нэгдсэн системд нийцүүлэх, иргэд, олон нийтэд үйлчлэх, мэдээллийн аюулгүй байдал, хэвийн ажиллагааг хангах, хамгаалах.

2.5.2.үйл ажиллагааны стратегийн 2 дугаар зорилтын хүрээнд:

2.5.2.1.яамны үйл ажиллагааны өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг хангах, төрийн захиргааны байгууллага болон хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангах, яамны албан хаагчдын ажиллах нөхцөл, чадавхыг дээшлүүлэх, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн үйл ажиллагааг дэмжих;

2.5.2.2.салбарын хүний нөөцийн хөгжил, сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг зохицуулалтаар хангах;

2.5.2.3.иргэд, байгууллагаас ирүүлсэн албан бичиг, өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэх үйл ажиллагаанд хяналт тавих;

2.5.2.4.хууль, эрх зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, Төрийн болон албаны нууцын тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах, зохицуулах;

2.5.2.5.эрхлэх асуудлын хүрээний хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн биелэлтийг хангах, яамны үйл ажиллагааг нэгтгэн төлөвлөх, тайлагнах, хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих;

2.5.2.6.яамны үйл ажиллагааны ил тод байдлыг хангах;

2.5.2.7.салбарын шагнал, урамшууллын асуудлыг эрхлэх, мэдээллийн санг бүрдүүлэх;

2.5.2.8.яамыг төлөөлж шүүх, прокурор, холбогдох хууль, хяналтын байгууллагатай харилцах;

2.5.2.9.сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагын үйл ажиллагааг чиг үүргийн хүрээнд удирдан чиглүүлэх;

2.5.2.10.эрхлэх асуудлын хүрээнд салбарын гадаад харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх, гадаад, дотоодод зохион байгуулах олон улсын арга хэмжээнд мэргэжлийн арга зүйн дэмжлэг үзүүлэх;

2.5.2.11.эрхлэх асуудлын хүрээнд бүс нутгийн болон олон улсын хэмжээнд Монгол Улсын талаарх сонирхолыг нэмэгдүүлэх, эерэгээр сурталчилан таниулах чиглэлээр мэдээлэл, сурталчилгааг бэлтгэн түгээх, бүс нутгийн түвшинд болон олон улсын хэмжээнд идэвхижүүлэх.

2.5.3.үйл ажиллагааны стратегийн 3 дугаар зорилтын хүрээнд:

2.5.3.1.соёлын талаарх хууль тогтоомж, бодлого, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенцын хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах, биелэлтийг хангуулах;

2.5.3.2.бүх нийтийн соёлын боловсрол олгох, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг идэвхжүүлэх;

2.5.3.3.үндэсний, сонгодог, орчин үеийн урлагийн төрлийг хөгжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах, удирдлага, зохион байгуулалтыг сайжруулах;

2.5.3.4.соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих, утга зохиол, ном хэвлэл, дүрслэх урлаг, дуу, хөгжим, тайзны урлаг, кино, дуу дүрсний урлаг, хэвлэл мэдээлэл, хувцас загвар, архитектур, дизайн, дижитал контент, тоглоом

хөгжүүлэлт, маркетинг, зар сурталчилгааны салбарыг хөгжүүлэх, үйл ажиллагааг зохион байгуулах;

2.5.3.5.төв, орон нутгийн мэргэжлийн урлагийн байгууллага, номын сан, соёлын төв, соёлын ордныг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах;

2.5.3.6.монгол хэл, бичиг, хэвлэл нийтлэлийн бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах, хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран ажиллах;

2.5.3.7.соёлын өвийг хамгаалах талаарх хууль тогтоомж, бодлого, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенцын хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах, биелэлтийг хангуулах;

2.5.3.8.соёлын өвийн хамгаалалтын чиглэлээр судалгаа, шинжилгээ хийх, салбарын удирдлага, зохион байгуулалтыг сайжруулах, хүний нөөцийг хөгжүүлэх ажлыг зохицуулах;

2.5.3.9.соёлын өвийг нээж илрүүлэх, хадгалах, хамгаалах, өвлүүлэх, бүс нутагтаа тэргүүлэх үзүүлэлтийг нэмэгдүүлэхэд чиглэсэн бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэх, төв, орон нутгийн музейн байгууллагыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах;

2.5.3.10.палеонтологи, археологийн эрдэм шинжилгээний болон авран хамгаалах судалгааны ажлыг зохицуулах;

2.5.3.11.түүх, соёлын дурсгалт зүйл, судалгааны дээжийг хилээр нэвтрүүлэх үйл ажиллагааг зохицуулах, хэрэгжилтэд нь хяналт тавих, тайлагнах;

2.5.3.12 нэгжийн үйл ажиллагааны үндсэн чиг үүргийн хүрээнд төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн байгууллага, иргэд, олон нийттэй хамтран ажиллах.

2.5.4.үйл ажиллагааны стратегийн 4 дүгээр зорилтын хүрээнд:

2.5.4.1.аялал, жуулчлалын талаарх хууль тогтоомж, бодлого, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенцын хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах, биелэлтийг хангуулах;

2.5.4.2.Монгол Улсад аялах сонирхлыг нэмэгдүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах, олон улсын экспо болон бусад арга хэмжээнд оролцох ажлыг зохион байгуулах, хэрэглэгчийг мэдээллээр хангах, жуулчдын тоог нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах, нэгдсэн удирдлагаар хангах;

2.5.4.3.аялал жуулчлалыг хөгжүүлж, хөрөнгө оруулалтыг дэмжих, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, ажлын байрыг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах;

2.5.4.4.байгаль, соёлын өвд тулгуурласан аялал жуулчлалын чөлөөт бүс, бүтээгдэхүүн, үйлчилгээг өргөжүүлэх, соёлын бүтээгдэхүүн, контентыг аялал жуулчлалтай хослуулан өргөжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах;

2.5.4.5.салбар хоорондын уялдааг хангасан аялал жуулчлалын бүс, нэгдсэн дэд бүтцийг төлөвлөх, хэрэгжүүлэх;

2.5.4.6. аялал, жуулчлалын мэдээллийг нэгтгэж дүн шинжилгээ хийх, мэдээллийн сан бүрдүүлж, зохицуулалтаар хангах;

2.5.4.7. аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээ болон байгууллагын стандартыг олон улсын жишигт нийцүүлэх, менежментийг сайжруулах, хэрэгжилтийг хангах талаар нутгийн захиргааны байгууллага, мэргэжлийн байгууллага, аж ахуйн нэгж, олон нийтийн байгууллага, иргэдийг мэргэжил, арга зүйн зөвлөгөөгөөр хангах;

2.5.4.8. аялал жуулчлалын байгууллага, аялал жуулчлалын мэргэжлийн холбооны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх;

2.5.4.9. нэгжийн үйл ажиллагааны үндсэн чиг үүргийн хүрээнд төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн байгууллага, иргэд, олон нийттэй хамтран ажиллах.

2.5.5. үйл ажиллагааны стратегийн 5 дугаар зорилтын хүрээнд

2.5.5.1. биеийн тамир, спортын талаарх хууль тогтоомж, бодлого, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенцын хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах, биелэлтийг хангуулах;

2.5.5.2. биеийн тамир, спортын чиглэлээр судалгаа, шинжилгээ хийх, салбарын удирдлага, зохион байгуулалтыг сайжруулах;

2.5.5.3. идэвхтэй хөдөлгөөнөөр хичээллэх дадлыг бий болгох, бие бялдрын боловсрол олгох, эрүүл, идэвхтэй амьдрах соёлыг нийгэмд төлөвшүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах;

2.5.5.4. бие бялдрын түвшин тогтоох сорилын үйлчилгээний чанарын болон гүйцэтгэлийн үнэлгээ хийх, хянах иж бүрэн тогтолцоог бүрдүүлэх, бодлого, зөвлөмж боловсруулах, түгээх, удирдлагаар хангах;

2.5.5.5. спортын төрлийг хөгжүүлэх, спортын холбоо, клубийн үйл ажиллагаанд зохион байгуулалтын дэмжлэг үзүүлэх, шигшээ багийн тамирчдыг бэлтгэх тогтолцоог бэхжүүлж, тамирчдын тив, дэлхий, олимпын түвшинд өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, мэргэжлийн спортыг дэмжих, допингоос урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах;

2.5.5.6. үндэсний болон мэргэжлийн спортыг дэмжин хөгжүүлэх;

2.5.5.7. биеийн тамир, спортоор хичээллэх орчин, нөхцөлийг сайжруулж, хүртээмжийг нэмэгдүүлэх;

2.5.5.8. улсын болон олон улсын хэмжээнд зохион байгуулагдах спортын наадам, тэмцээн, арга хэмжээг төлөвлөх, мэргэжил, арга зүйн зөвлөгөөгөөр хангах, дэмжлэг үзүүлэх;

2.5.5.9. залуучуудын хөгжлийг дэмжих талаарх хууль тогтоомж, бодлого, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенцын хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах, биелэлтийг хангуулах;

2.5.5.10.залуучуудын хувь хүний хөгжил болон нийгэм, эдийн засгийн хөгжилд хувь нэмрээ оруулахад шаардлагатай бүх төрлийн дэмжлэг, туслалцааг үзүүлэх, орчин, нөхцөл бүрдүүлэх;

2.5.5.11 залуучуудын хөдөлмөр эрхлэлт, сайн дурын ажлыг дэмжих, оролцоог хангасан таатай нөхцөл бүрдүүлэх үйл ажиллагааг удирдлага арга зүйгээр хангах;

2.5.5.12.нэгжийн үйл ажиллагааны үндсэн чиг үүргийн хүрээнд төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн байгууллага, иргэд, олон нийттэй хамтран ажиллах.

2.5.6.Үйл ажиллагааны стратегийн 6 дугаар зорилтын хүрээнд:

2.5.6.1.төсвийн ерөнхийлөн захирагчийн урсгал, хөрөнгө оруулалтын зардлын жилийн болон дунд хугацааны төсвийг төлөвлөх, төсвийг зориулалтын дагуу зарцуулах, тайлагнах;

2.5.6.2.эрхлэх асуудлын хүрээний хөрөнгө оруулалтын төлөвлөлтийг оновчтой боловсруулах, хэрэгжилтийг удирдлага, зохион байгуулалтаар хангах, хөрөнгө оруулалтын мэдээллийн цахим сан бүрдүүлэх, хөгжүүлэх, шинжилгээ хийх, мэдээллээр хангах төсвийн ерөнхийлөн захирагчийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, хяналт тавих, тайлагнах;

2.5.6.3.төсвийн ерөнхийлөн захирагчийн төрийн өмчийн бүртгэлд, хяналт тавих, тайлагнах;

2.5.6.4.төсвийн ерөнхийлөн захирагчийн төрийн сангийн төлбөр тооцоог хийх;

2.5.6.5.төсвийн ерөнхийлөн захирагчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн тайлагнал;

2.5.6.6.төсвийн ерөнхийлөн захирагчийн төсөл, хөтөлбөрийн төлөвлөлт, хэрэгжилтэд хяналт тавих, тайлагнах;

2.5.6.7.салбарын алба хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх;

2.5.6.8.харьяа төсөвт нэгжийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах;

2.5.6.9.нэгжийн үйл ажиллагааны үндсэн чиг үүргийн хүрээнд төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн байгууллага, иргэд, олон нийттэй хамтран ажиллах.

2.5.7.Үйл ажиллагааны стратегийн 7 дугаар зорилтын хүрээнд:

2.5.7.1.салбарын хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, төлөвлөгөө, төслийн хэрэгжилтийн явц, үр нөлөө, зорилгод хүрч байгаа байдалд хяналт-

шинжилгээ, үнэлгээ хийх, хөндлөнгийн байгууллагаар хэрэглэгчийн үнэлгээ хийлгэх ажлыг зохион байгуулах;

2.5.7.2.сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллага, яамны зохион байгуулалтын бүтцийн нэгжийн үйл ажиллагаа, үр дүнг үнэлэх ажлыг зохион байгуулах;

2.5.7.3.сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллагын үйл ажиллагаанд дотоод аудит хийх;

2.5.7.4.салбарын хэмжээнд эрсдэлийн үнэлгээ хийх;

2.5.7.5.сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагад хяналт шалгалт хийх аргачлал боловсруулах, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, хэрэгжүүлэх, хууль тогтоомжийн хэрэгжилтийг мөрдүүлэх;

2.5.7.6.сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллага болон бусад байгууллагад соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын хөгжлийг дэмжих үйлчилгээ, хууль тогтоомжийн хэрэгжилтийн хяналт шалгалтыг гүйцэтгэх, салбарын эрсдэлийн удирдлагыг нэгдсэн зохион байгуулалт, зохицуулалтаар хангах;

2.5.7.7.соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын хөгжлийг дэмжих үйлчилгээтэй холбоотой гомдлыг шийдвэрлэх, нэгдсэн бүртгэл, мэдээллийн үйл ажиллагааг зохион байгуулах зохицуулах;

2.5.7.8.салбарын улсын байцаагчдыг мэргэжлийн арга зүй, шуурхай удирдлага, зохион байгуулалтаар хангах, мэргэшүүлэх.

2.6.Яамны үйл ажиллагааны зорилт

Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны үйл ажиллагааны гол зорилтын хүрээнд түүнийг хэрэгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааны зорилтуудыг тодорхойлж, тус яамны зохион байгуулалтын бүтцийн нэгжүүдийн үйл ажиллагааны стратеги, албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтод тусган хэрэгжүүлнэ.

2.7.Яамны үйл ажиллагааны стратегийн загвар

Яамны үйл ажиллагааны стратегийн загварыг дор дурдсанаар тодорхойлж байна:

Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны үйл ажиллагааны стратегийн загвар

Үйл ажиллагааны стратеги
зорилт

Үйл ажиллагааны гол зорилт

Эрхэм зорилго

Соёлын өвийг хадгалан хамгаалж, үндэсний соёлын үнэ цэнийг нэмэгдүүлж, Монгол хүний авьяас, чадвар, залуучуудын хөгжил, оролцоог дэмжин, хүн амын бие бялдрыг хөгжүүлж, спортын амжилтыг дэлхийд ахиулж, үндэсний онцлогтой тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэн эдийн засагт оруулах үр өгөөжийг нэмэгдүүлж, соёлын бүтээлч үйлдвэрлэлийг эдийн засгийн бие даасан салбар болгон хөгжүүлэх замаар үндэсний нэгдмэл үнэт зүйлийг бэхжүүлэхэд оршино.	-соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын хөгжил, оролцоог дэмжих нэгдсэн бодлого тодорхойлох; -салбарын мэдээлэл технологийн хөгжлийн бодлого, төлөвлөлтийг тодорхойлж, мэдээллийн тогтолцоог бүрдүүлж, дижитал шилжилтийг эрчимжүүлэх; -эрхлэх асуудлын хүрээний статистикийн мэдээллийг боловсронгуй болгох, дүн шинжилгээ хийх, салбарын нэгдсэн судалгаа, мэдээллийн тогтолцоог бүрдүүлэх; Төрийн захиргааны удирдлага, зохион байгуулалтыг хэрэгжүүлэх, албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг сайжруулах - Салбарын хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох - гадаад хамтын ажиллагааг хөгжүүлж, бэхжүүлэх, мэдээлэл сурталчилгааг олон нийтэд түгээх. -соёл, урлагийг хөгжүүлж, олон улсад өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх; -соёлын бүтээлч үйлдвэрлэлийг эдийн засгийн бие даасан салбар болгох; -иргэдийн соёлын боловсролыг дээшлүүлэх, олон нийт, нийгмийг соён гэгээрүүлэх;	-эрхлэх асуудлын хүрээний тэргүүлэх чиглэл, нэгдсэн бодлогыг тодорхойлж, төлөвлөх, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, хэрэгжилтийг бодлогын нэгдсэн арга зүйгээр дэмжиж, салбар дундын уялдааг хангах; -эрхлэх асуудлын хүрээний салбарын эдийн засаг, санхүү, цалин хөлс, гадаадын зээл, тусламж, төр, хувийн хэвшлийн түншлэлийн бодлогыг боловсруулах, төлөвлөх, эрх зүйн орчныг боловсронгуй болгох; -эрхлэх асуудлын хүрээнд судалгаа, эрдэм шинжилгээний тэргүүлэх чиглэлийг салбарын бодлогод нийцүүлэн боловсруулах, төлөвлөх, судалгаа, шинжилгээний ажлын үр дүнг практикт нэвтрүүлэх ажлыг нэгдсэн удирдлагаар хангах; -эрхлэх асуудлын хүрээний статистикийн мэдээллийг олон улсын аргачлалтай уялдуулах, нэгтгэх, боловсруулах, дүн шинжилгээ хийх, мэдээллийн сан бүрдүүлэх, хэрэглэгчийг мэдээллээр хангах; -эрхлэх асуудлын хүрээний удирдлагын мэдээллийн тогтолцоог бүрдүүлэх, салбарын бодлогыг мэдээллийн технологиор дэмжих, үйл ажиллагааг цахимжуулах, төрийн цахим нэгдсэн системд нийцүүлэх, иргэд, олон нийтэд үйлчлэх, мэдээллийн аюулгүй байдал, хэвийн ажиллагааг хангах, хамгаалах. -яамны үйл ажиллагааны өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг хангах, төрийн захиргааны байгууллага болон хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангах, яамны албан хаагчдын ажиллах нөхцөл, чадавхыг дээшлүүлэх, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн үйл ажиллагааг дэмжих; -иргэд, байгууллагаас ирүүлсэн албан бичиг, өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэх үйл ажиллагаанд хяналт тавих; -хууль, эрх зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, Төрийн болон албаны нууцын тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах, зохицуулах; -эрхлэх асуудлын хүрээний хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн биелэлтийг хангах, яамны үйл ажиллагааг нэгтгэн төлөвлөх, тайлагнах, хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих; -яамны үйл ажиллагааг нийтэд сурталчлах ажлыг зохион байгуулах, үйл ажиллагааны ил тод байдлыг хангах; -салбарын шагнал, урамшууллын асуудлыг эрхлэх, мэдээллийн санг бүрдүүлэх; -яамыг төлөөлж шүүх, прокурор, холбогдох хууль, хяналтын байгууллагатай харилцах; -сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагын үйл ажиллагааг чиг үүргийн хүрээнд удирдан чиглүүлэх. -эрхлэх асуудлын хүрээний үйл ажиллагааг бүс нутгийн болон олон улсын хэмжээнд идэвхжүүлэх; -олон улс болон дотоод зохион байгуулах олон улсын түвшний арга хэмжээний зохион байгуулалтад удирдлагад дэмжлэг үзүүлэх; -гадаадын зээл тусламжаар хэрэгжих төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх. - эрхлэх асуудлын хүрээнд бүс нутгийн болон олон улсын хэмжээнд Монгол улсын талаарх сонирхолыг нэмэгдүүлэх, эерэгээр сурталчилан таниулах чиглэлээр мэдээлэл, сурталчилгааг бэлтгэн түгээх, бүс нутгийн түвшинд болон олон улсын хэмжээнд идэвхижүүлэх. -соёл, соёлын өв, музей, номын сан, кино, соёлын бүтээлч үйлдвэрлэлийн талаарх хууль тогтоомж, бодлого, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенцын хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах, биелэлтийг хангуулах; -бүх нийтийн соёлын боловсрол олгох, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг идэвхжүүлэх;
--	---	---

	-соёлын өвийн хамгаалах, хөгжүүлэх, зохистойгоор ашиглах арга хэмжээг сайжруулах; -иргэдийн бие бялдрын боловсролыг дээшлүүлэх, биеийн тамир, спортыг хөгжүүлэх, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх; - залуучуудын хөгжил оролцоог дэмжиж, үнэлэмжийг нэмэгдүүлэх; тогтвортой хөгжлийг дэмжсэн дөрвөн улирлын аялал жуулчлалыг хөгжүүлэх, дэд бүтцийн чанар, хүртээмжийг сайжруулж, нийгэм, эдийн засагт оруулах хувь нэмрийг нэмэгдүүлэх;	-үндэсний, сонгодог, орчин үеийн урлагийн төрлийг хөгжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах, удирдлага, зохион байгуулалтыг сайжруулах; -соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих, утга зохиол, ном хэвлэл, дүрслэх урлаг, дуу, хөгжим, тайзны урлаг, кино, дуу дүрсний урлаг, хэвлэл мэдээлэл, хувцас загвар, архитектур, дизайн, дижитал контент, тоглоом хөгжүүлэлт, маркетинг, зар сурталчилгааны салбарыг хөгжүүлэх, үйл ажиллагааг зохион байгуулах; -төв, орон нутгийн мэргэжлийн урлагийн байгууллага, номын сан, соёлын төв, соёлын ордныг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах; -монгол хэл, бичиг, хэвлэл нийтлэлийн бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах, хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран ажиллах; -соёлын өвийн хамгаалалтын чиглэлээр судалгаа, шинжилгээ хийх, салбарын удирдлага, зохион байгуулалтыг сайжруулах, хүний нөөцийг хөгжүүлэх ажлыг зохицуулах; -соёлын өвийг нээж илрүүлэх, хадгалах, хамгаалах, өвлүүлэх, бүс нутагтаа тэргүүлэх үзүүлэлтийг нэмэгдүүлэхэд чиглэсэн бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэх, төв, орон нутгийн музейн байгууллагыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах; -палеонтологи, археологийн эрдэм шинжилгээний болон авран хамгаалах судалгааны ажлыг зохицуулах; -түүх, соёлын дурсгалт зүйл, судалгааны дээжийг хилээр нэвтрүүлэх үйл ажиллагааг зохицуулах, хэрэгжилтэд нь хяналт тавих, тайлагнах; -нэгжийн үйл ажиллагааны үндсэн чиг үүргийн хүрээнд төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн байгууллага, иргэдтэй хамтран ажиллах. -биеийн тамир, спорт, залуучуудын хөгжлийн талаарх хууль тогтоомж, бодлого, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенцын хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах, биелэлтийг хангуулах; -биеийн тамир, спортын чиглэлээр судалгаа, шинжилгээ хийх, салбарын удирдлага, зохион байгуулалтыг сайжруулах; -идэвхтэй хөдөлгөөнөөр хичээллэх дадлыг бий болгох, бие бялдрын боловсрол олгох, эрүүл, идэвхтэй амьдрах соёлыг нийгэмд төлөвшүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах; -бие бялдрын түвшин тогтоох сорилын үйлчилгээний чанарын болон гүйцэтгэлийн үнэлгээ хийх, хянах иж бүрэн тогтолцоог бүрдүүлэх, бодлого, зөвлөмж боловсруулах, түгээх, удирдлагаар хангах; -спортын төрлийг хөгжүүлэх, шигшээ багийн тамирчдыг бэлтгэх тогтолцоог бэхжүүлж, тамирчдын тив, дэлхий, олимпын түвшинд өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, мэргэжлийн спортыг дэмжих ажлыг зохион байгуулах; -үндэсний болон мэргэжлийн спортыг дэмжин хөгжүүлэх; -биеийн тамир, спортоор хичээллэх орчин, нөхцөлийг сайжруулж, хүртээмжийг нэмэгдүүлэх, -улсын болон олон улсын хэмжээнд зохион байгуулагдах спортын наадам, тэмцээн, арга хэмжээг төлөвлөх, мэргэжил, арга зүйн зөвлөгөөгөөр хангах, дэмжлэг үзүүлэх. -залуучуудын хувь хүний хөгжил болон нийгэм, эдийн засгийн хөгжилд хувь нэмрээ оруулахад шаардлагатай бүх төрлийн дэмжлэг, тусалцааг үзүүлэх, орчин, нөхцөл бүрдүүлэх; -залуучуудын хөдөлмөр эрхлэлт, сайн дурын ажлыг дэмжих, оролцоог хангасан таатай нөхцөл бүрдүүлэх үйл ажиллагааг удирдлага арга зүйгээр хангах. -аялал, жуулчлалын талаарх талаарх хууль тогтоомж, бодлого, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенцын хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах, биелэлтийг хангуулах; -Монгол Улсад аялах сонирхлыг нэмэгдүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах, олон улсын экспо болон бусад арга хэмжээнд оролцох ажлыг зохион байгуулах, хэрэглэгчийг мэдээллээр хангах, жуулчдын тоог нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах, нэгдсэн удирдлагаар хангах; -аялал жуулчлалыг хөгжүүлж, хөрөнгө оруулалтыг дэмжих, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, ажлын байрыг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах; -байгаль, соёлын өвд тулгуурласан аялал жуулчлалын чөлөөт бүс, бүтээгдэхүүн, үйлчилгээг өргөжүүлэх, соёлын бүтээгдэхүүн, контентыг аялал жуулчлалтай хослуулан өргөжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах; -салбар хоорондын уялдааг хангасан аялал жуулчлалын бүс, нэгдсэн дэд бүтцийг төлөвлөх, хэрэгжүүлэх; -аялал, жуулчлалын мэдээллийг нэгтгэж дүн шинжилгээ хийх, мэдээллийн сан бүрдүүлж, зохицуулалтаар хангах; -аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээ болон байгууллагын стандартыг олон улсын жишигт нийцүүлэх, менежментийг сайжруулах, хэрэгжилтийг хангах талаар нутгийн захиргааны байгууллага, мэргэжлийн байгууллага,
--	--	---

	Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсөв, хөрөнгө оруулалтыг төлөвлөх, хэрэгжүүлэх -Эрхлэх асуудлын хүрээний бодлогын хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хийх - Хяналт, шалгалт хийх	аж ахуйн нэгж, олон нийтийн байгууллага, иргэдийг мэргэжил, арга зүйн зөвлөгөөгөөр хангах; -аялал жуулчлалын байгууллага, аялал жуулчлалын мэргэжлийн холбооны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх; -төсвийн ерөнхийлөн захирагчийн урсгал, хөрөнгө оруулалтын зардлын жилийн болон дунд хугацааны төсвийг төлөвлөх, төсвийг зориулалтын дагуу зарцуулах, тайлагнах; -эрхлэх асуудлын хүрээний хөрөнгө оруулалтын төлөвлөлтийг оновчтой боловсруулах, хэрэгжилтийг удирдлага, зохион байгуулалтаар хангах, хөрөнгө оруулалтын мэдээллийн цахим сан бүрдүүлэх, хөгжүүлэх, шинжилгээ хийх, мэдээллээр хангах төсвийн ерөнхийлөн захирагчийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, хяналт тавих, тайлагнах; -төсвийн ерөнхийлөн захирагчийн төрийн өмчийн бүртгэлд, хяналт тавих, тайлагнах; -төсвийн ерөнхийлөн захирагчийн төрийн сангийн төлбөр тооцоог хийх; -төсвийн ерөнхийлөн захирагчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн тайлагнал; -төсвийн ерөнхийлөн захирагчийн төсөл, хөтөлбөрийн төлөвлөлт, хэрэгжилтэд хяналт тавих, тайлагнах; -салбарын алба хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх; -харьяа төсөвт нэгжийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, яамны санхүү, аж ахуйн үйл ажиллагааг тасралтгүй явуулах ажлыг хууль тогтоомжийн хүрээнд хариуцах чиг үүргийг хэрэгжүүлэх. -сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллага, яамны зохион байгуулалтын бүтцийн нэгжийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ болон хяналт шалгалт хийх аргачлал боловсруулах, аргачлалын хэрэгжилтийг хангах, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулах; -хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх, хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ хийх. -салбарын хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, төлөвлөгөө, төслийн хэрэгжилтийн явц, үр нөлөө, зорилгод хүрч байгаа байдалд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, хөндлөнгийн байгууллагаар хэрэглэгчийн үнэлгээ хийлгэх ажлыг зохион байгуулах; -сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллагын үйл ажиллагаанд дотоод аудит хийх; -салбарын хэмжээнд эрсдэлийн үнэлгээ хийх, салбарын төвлөрсөн бус статистик мэдээллийг эрхлэн хөтлөх; -сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллага болон бусад байгууллагад соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын хөгжлийг дэмжих үйлчилгээ, хууль тогтоомжийн хэрэгжилтийн хяналт шалгалтыг гүйцэтгэх, салбарын эрсдэлийн удирдлагыг нэгдсэн зохион байгуулалт, зохицуулалтаар хангах; -соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын хөгжлийг дэмжих үйлчилгээтэй холбоотой гомдлыг шийдвэрлэх, нэгдсэн бүртгэл, мэдээллийн үйл ажиллагааг зохион байгуулах зохицуулах; -салбарын улсын байцаагчдыг мэргэжлийн арга зүй, шуурхай удирдлага, зохион байгуулалтаар хангах, мэргэшүүлэх.
--	--	---

Гурав.Яамны үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцоо, зохион байгуулалтын бүтэц, тэдгээрийн үндсэн үүрэг, чиг үүрэг

3.1. Бүтцийн ерөнхий тогтолцоо боловсруулахад баримтлах зарчим

Яамны үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцоо, зохион байгуулалтын бүтцийг боловсруулахад дараах зарчмыг баримтлав:

3.1.1.яамны стратегийн зорилтыг бүтцэд тусгасан байх зарчим (тухайн яамны үйл ажиллагааны бүтцийн тогтолцоо, зохион байгуулалтын бүтэц нь түүний үйл ажиллагааны стратегийн зорилттой уялдсан байх);

3.1.2.эрх мэдлийн ялгаа, зааг нь тодорхой, итгэл хүлээхүйц байх зарчим (бүтцийн нэгжүүд, тэдгээрийн удирдах албан тушаалын түвшин, нэр нь аль нэгж ямар асуудал эрхэлдэг, аль албан тушаал ямар эрх мэдэлтэй болохыг тодорхой

мэдэж болохуйц байх, тэдгээрийн ажлын уялдаа, ажиллах чадвар нь итгэл хүлээхүйц байхын зэрэгцээ сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлагийн зорилт, чиг үүрэгтэй давхардахгүй байх);

3.1.3.үзэгдэхүйц үйлчилгээний болон стратегийн удирдлагын баримжаатай байх зарчим (байгууллагын нэр, бүтцээс тухайн байгууллагын үйл ажиллагааны дүр төрх харагдахуйц байх, тухайлбал, яамны бүтэц, зохион байгуулалтын бүтцийн нэгжийн нэр нь түүний үйл ажиллагааны стратегийг тусгасан байх);

3.1.4.бүтцийн хувьд энгийн байх зарчим (Төрийн нарийн бичгийн даргаас албан хаагч хүртэл гурваас дээшгүй шат дамжлагатай байх);

3.1.5.тэнцвэрийг хангах, хяналтын хүрээг тогтоох зарчим (байгууллагын үйл ажиллагааны стратеги, бүтэц хоёрын зөв зохистой тэнцвэрийг хангах замаар аль болох хялбар удирдах, хянах боломжтой байх, үйл ажиллагааны стратегийн зорилтыг аль болох оновчтой бүлэглэх замаар бүтцийн ерөнхий тогтолцоог тогтоосон байх, энэ нь удирдлагын чиг үүрэг, хүний болон бусад нөөцийг зөв хуваарилан, хэрэглэгчийн хэрэгцээнд нийцсэн үйлчилгээ үзүүлэх боломж бүрдүүлсэн байх);

3.1.6.улс төржихгүй байх зарчим (тухайн яамны албан хаагч нь эрхэлсэн сайд, Засгийн газар, бусад үйлчлүүлэгч буюу хэрэглэгчид өндөр мэргэшлийн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, улс төрийн аливаа нөлөөлөлд автахгүй, төвийг сахисан байх);

3.1.7.хангалттай чадавх, бодитой үйл ажиллагааны зарчим (үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцооны загвар, зохион байгуулалтын бүтэц нь чадавхаа бүрэн илрүүлэхэд чиглэсэн, хэрэгжихүйц бөгөөд ажиллах чадвартай байх).

3.2.Үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцооны загвар

Дээр дурдсан зарчим болон яамны үйл ажиллагааны стратегийн загварыг үндэслэн тус яамны үйл ажиллагааны бүтцийн дараах ерөнхий тогтолцооны загварыг санал болгож байна:

Удирдлага (Сайд, Төрийн нарийн бичгийн дарга)		
Бодлого төлөвлөлтийн нэгж		Төрийн захиргааны удирдлагын нэгж
Соёл, урлагийн бодлого зохицуулалтын нэгж		Санхүү, хөрөнгө оруулалтын нэгж
Аялал жуулчлалын бодлого зохицуулалтын нэгж		Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын нэгж
Биеийн тамир, спорт, залуучуудын бодлого зохицуулалтын нэгж		

3.3.Зохион байгуулалтын бүтэц

Яамны үйл ажиллагааны стратегийн загвараас үндэслэн доор дурдсан зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд дараах үндсэн үүрэг, чиг үүрэгтэй:

3.3.1.Бодлого төлөвлөлтийн асуудал хариуцсан нэгж, түүний үндсэн чиг үүрэг:

Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн 1 дүгээр зорилтын хүрээнд эрхлэх асуудлын хүрээний тэргүүлэх чиглэл, нэгдсэн бодлогыг тодорхойлж, төлөвлөх, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, хэрэгжилтийг бодлогын нэгдсэн арга зүйгээр дэмжиж, салбар дундын уялдааг хангах, эрхлэх асуудлын хүрээний салбарын эдийн засаг, гадаадын зээл, тусламж, төр, хувийн хэвшлийн түншлэлийн бодлогыг боловсруулах, төлөвлөх, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, эрхлэх асуудлын хүрээнд судалгаа, эрдэм шинжилгээний тэргүүлэх чиглэлийг салбарын бодлогод нийцүүлэн боловсруулах, төлөвлөх, судалгаа, шинжилгээний ажлын үр дүнг хэрэглээнд нэвтрүүлэх ажлыг нэгдсэн удирдлагаар хангах үндсэн үүрэг хүлээж ажиллана.

Энэ нэгжийн чиг үүргийн хүрээнд цахим хөгжил, статистикийн нэгж ажиллана.

Энэ нэгжийн үйл ажиллагааны үндсэн чиг үүрэг нь эрхлэх асуудлын хүрээний статистикийн мэдээллийг олон улсын аргачлалтай уялдуулах, нэгтгэх, боловсруулах, дүн шинжилгээ хийх, мэдээллийн сан бүрдүүлэх, хэрэглэгчийг мэдээллээр хангах, эрхлэх асуудлын хүрээний удирдлагын мэдээллийн тогтолцоог бүрдүүлэх, салбарын бодлогыг мэдээллийн технологи, инновациар дэмжих, үйл ажиллагааг цахимжуулах, төрийн цахим нэгдсэн системд нийцүүлэх, иргэд, олон нийтэд үйлчлэх, мэдээллийн аюулгүй байдал, хэвийн ажиллагааг хангах, хамгаалах, эрхлэх асуудлын хүрээний нэгдсэн арга хэмжээг төлөвлөх, нэгдсэн арга зүйгээр хангахад чиглэгдэнэ.

Нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь сайд, яамны Төрийн нарийн бичгийн дарга, зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд, албан хаагчид, салбарын байгууллага, аж ахуйн нэгж, иргэд байх бөгөөд шууд бус хэрэглэгч нь яамд, Засгийн газрын агентлаг, нутгийн захиргааны байгууллага, бусад хэрэглэгч байна. Энэ үйлчилгээг үзүүлэхэд оролцох гол түнш нь Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, холбогдох бусад яам, төрийн болон төрийн бус байгууллагууд, иргэд байна.

3.3.2.Төрийн захиргааны удирдлагын асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний үндсэн үүрэг, чиг үүрэг:

Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн 2 дугаар зорилтын хүрээнд төрийн захиргааны болон салбарын хүний нөөцийн бодлогын хэрэгжилт, удирдлагын манлайллаар хангах, албан хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх болон ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангахад дэмжлэг үзүүлэх, тайланг нэгтгэх, хариуцлага тооцох тогтолцоог боловсронгуй болгох, удирдлагын манлайллаар хангах, харьяа байгууллагын удирдлагын үйл ажиллагааг төрийн захиргааны удирдлагаар хангах, яамны үйл ажиллагааны гүйцэтгэлийн төлөвлөгөө батлуулах, төсвийн ерөнхийлөн захирагчаас аймаг, нийслэлийн Засаг дарга болон яамны болон харьяа төсвийн шууд захирагчтай гүйцэтгэлийн гэрээ байгуулах, тэдгээрийн хэрэгжилтийг удирдан зохион байгуулах, холбогдох албан хаагчдын томилгоо болон чөлөөлөх асуудлыг боловсруулж, шийдвэрлүүлэх, иргэд байгууллагаас ирсэн өргөдөл, гомдол, санал хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэлтэд хяналт тавих, нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, яамны тасралтгүй, хэвийн үйл ажиллагаа, ил тод нээлттэй байдлыг хангах, яамны албан хэргийг хөтлөх, байгууллагын соёлыг төлөвшүүлэх, эрх зүйн

зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, сайдын эрхлэх асуудлын хүрээний болон яамны гадаад хамтын ажиллагааны чиглэлээр олон улсын гэрээ хэлэлцээр байгуулах, төсөл хөтөлбөрийн хэрэгжилтийг уялдуулан зохицуулах ажлыг удирдлага зохион байгуулалтаар хангах, эрхлэх асуудлын хүрээний бодлого төлөвлөлт, хэрэгжүүлэлтийн мэдээлэл болон олон улсад Монгол Улсын талаарх сонирхолыг нэмэгдүүлэх, эерэгээр сурталчилан таниулах чиглэлээр мэдээлэл, сурталчилгааг бэлтгэн бүс нутгийн түвшинд болон олон улсын хэмжээнд идэвхижүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд чиглэгдэнэ.

Энэ нэгжийн чиг үүргийн хүрээнд гадаад хамтын ажиллагаа хариуцсан нэгж ажиллана.

Энэ нэгжийн үйл ажиллагааны чиг үүрэг нь соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын салбарын болон яамны гадаад хамтын ажиллагааны чиглэлээр олон улсын гэрээ, хэлэлцээр байгуулах, төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийг уялдуулан зохицуулах, олон улсын хурал, уулзалт зохион байгуулах, яамны гадаад харилцаа, хамтын ажиллагааг зохион байгуулалтаар хангах, олон улсын төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх, холбогдох нэгжтэй хамтран хөгжлийн байгууллагын хамтын ажиллагааны зохицуулалтыг хангах үндсэн үүрэг хүлээж ажиллана.

Нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь сайд, яамны Төрийн нарийн бичгийн дарга, зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд байх бөгөөд шууд бус хэрэглэгч нь яамд, Засгийн газрын агентлаг, нутгийн захиргааны байгууллага, олон улсын байгууллагууд болон бусад хэрэглэгч байна. Энэ үйлчилгээг үзүүлэхэд оролцох гол түнш нь Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Гадаад харилцааны яам, холбогдох бусад яам, төрийн болон төрийн бус байгууллагууд, иргэд байна.

Энэ нэгжийн чиг үүргийн хүрээнд хууль, эрх зүйн асуудал хариуцсан нэгж ажиллана.

Энэ нэгжийн үйл ажиллагааны чиг үүрэг нь хууль, эрх зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, Төрийн болон албаны нууцын тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах, зохицуулах, тушаал, гэрээ, хэлэлцээрийн төсөл боловсруулах, санал өгөх, холбогдох нэгжид мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх, эрх зүйн маргаанд яамыг төлөөлөн оролцох, хууль, шүүхийн байгууллагын шийдвэрийн биелэлтийг хангуулахад сайд, яамны Төрийн нарийн бичгийн даргад цаг үеэ олсон мэргэшлийн зөвлөгөө, шуурхай мэдээлэл, үйлчилгээ, бүх талын дэмжлэг үзүүлэхэд чиглэгдэнэ.

Нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь сайд, яамны Төрийн нарийн бичгийн дарга, зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд, албан хаагчид, салбарын байгууллага, аж ахуйн нэгж, иргэд байх бөгөөд шууд бус хэрэглэгч нь яамд, Засгийн газрын агентлаг, нутгийн захиргааны байгууллага, бусад хэрэглэгч байна.

Энэ нэгжийн чиг үүргийн хүрээнд мэдээлэл, сурталчилгааны нэгж ажиллана.

Энэ нэгжийн үйл ажиллагааны үндсэн чиг үүрэг нь эрхлэх асуудлын хүрээний бодлого төлөвлөлт, хэрэгжүүлэлтийн мэдээлэл болон олон улсад Монгол Улсын талаарх сонирхолыг нэмэгдүүлэх, эерэгээр сурталчилан таниулах

чиглэлээр мэдээлэл, сурталчилгааг бэлтгэн бүс нутгийн түвшинд болон олон улсын хэмжээнд идэвхижүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд чиглэгдэнэ.

Нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь сайд, яамны Төрийн нарийн бичгийн дарга, зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд, албан хаагчид, салбарын байгууллага, аж ахуйн нэгж, иргэд, олон нийт байх бөгөөд шууд бус хэрэглэгч нь яамд, Засгийн газрын агентлаг, нутгийн захиргааны байгууллага олон улсын байгууллага, бусад хэрэглэгч байна.

Энэ үйлчилгээг үзүүлэхэд оролцох гол түнш нь Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, холбогдох бусад яам, төрийн болон төрийн бус байгууллагууд, иргэд байна.

3.3.3.Соёл, урлагийн бодлого зохицуулалтын асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний үндсэн үүрэг, чиг үүрэг:

Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн 3 дугаар зорилтын хүрээнд соёлын талаарх хууль тогтоомж, бодлого, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенцын хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах, биелэлтийг хангуулах, бүх нийтийн соёлын боловсрол олгох, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг идэвхжүүлэх, үндэсний, сонгодог, орчин үеийн урлагийн төрлийг хөгжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах, удирдлага, зохион байгуулалтыг сайжруулах, соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих, утга зохиол, ном хэвлэл, дүрслэх урлаг, дуу, хөгжим, тайзны урлаг, кино, дуу дүрсний урлаг, хэвлэл мэдээлэл, хувцас загвар, архитектур, дизайн, дижитал контент, тоглоом хөгжүүлэлт, маркетинг, зар сурталчилгааны салбарыг хөгжүүлэх, үйл ажиллагааг зохион байгуулах, төв, орон нутгийн мэргэжлийн урлагийн байгууллага, номын сан, соёлын төв, соёлын ордныг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, монгол хэл, бичиг, хэвлэл нийтлэлийн бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах, хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран ажиллахад чиглэнэ.

Энэ нэгжийн чиг үүргийн хүрээнд соёлын өвийн асуудал хариуцсан нэгж ажиллана.

Энэ нэгжийн үйл ажиллагааны чиг үүрэг нь соёлын өвийг хамгаалах талаарх хууль тогтоомж, бодлого, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенцын хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах, биелэлтийг хангуулах, соёлын өвийн хамгаалалтын чиглэлээр судалгаа, шинжилгээ хийх, салбарын удирдлага, зохион байгуулалтыг сайжруулах, хүний нөөцийг хөгжүүлэх ажлыг зохицуулах, соёлын өвийг нээж илрүүлэх, хадгалах, хамгаалах, өвлүүлэх, бүс нутагтаа тэргүүлэх үзүүлэлтийг нэмэгдүүлэхэд чиглэсэн бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэх, төв, орон нутгийн музейн байгууллагыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, палеонтологи, археологийн эрдэм шинжилгээний болон авран хамгаалах судалгааны ажлыг зохицуулах, түүх, соёлын дурсгалт зүйл, судалгааны дээжийг хилээр нэвтрүүлэх үйл ажиллагааг зохицуулах, хэрэгжилтэд нь хяналт тавих, тайлагнах, нэгжийн үйл ажиллагааны үндсэн чиг үүргийн хүрээнд төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн байгууллага, иргэдтэй хамтран ажиллаж, сайд, яамны Төрийн нарийн бичгийн даргад цаг үеэ олсон мэргэшлийн зөвлөгөө, шуурхай мэдээлэл, үйлчилгээ, бүх талын дэмжлэг үзүүлэхэд чиглэгдэнэ.

Энэ нэгжийн үйл ажиллагааны чиг үүрэг нь сайдын эрхлэх асуудлын хүрээний стратегийн бодлого болон соёлын өвийг хамгаалах бодлого, хууль тогтоомж, төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах, төрийн захиргааны

болон нутгийн захиргааны байгууллага, соёл, урлагийн байгууллагын хоорондын уялдаа холбоог хангах, мэргэжил, арга зүйн удирдлага, мэдээллээр хангахад чиглэгдэнэ.

Энэ нэгжийн үндсэн үйлчлүүлэгч нь сайд, яамны Төрийн нарийн бичгийн дарга, соёл, урлагийн байгууллага, их, дээд сургууль, эрдэмтэн, судлаач, иргэд байх бөгөөд шууд бус хэрэглэгч нь бусад яам, Засгийн газрын тохируулагч, хэрэгжүүлэгч агентлаг, нутгийн захиргааны байгууллага, төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшил, иргэд байна.

3.3.4. Аялал жуулчлалын бодлого зохицуулалтын асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний үндсэн үүрэг, чиг үүрэг:

Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн 4 дүгээр зорилтын хүрээнд аялал, жуулчлалын талаарх талаарх хууль тогтоомж, бодлого, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенцын хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах, биелэлтийг хангуулах, Монгол Улсад аялах сонирхлыг нэмэгдүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах, олон улсын экспо болон бусад арга хэмжээнд оролцох ажлыг зохион байгуулах, хэрэглэгчийг мэдээллээр хангах, жуулчдын тоог нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах, нэгдсэн удирдлагаар хангах, аялал жуулчлалыг хөгжүүлж, хөрөнгө оруулалтыг дэмжих, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, ажлын байрыг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах, байгаль, соёлын өвд тулгуурласан аялал жуулчлалын чөлөөт бүс, бүтээгдэхүүн, үйлчилгээг өргөжүүлэх, соёлын бүтээгдэхүүн, контентыг аялал жуулчлалтай хослуулан өргөжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах, салбар хоорондын уялдааг хангасан аялал жуулчлалын бүс, нэгдсэн дэд бүтцийг төлөвлөх, хэрэгжүүлэх, аялал, жуулчлалын мэдээллийг нэгтгэж дүн шинжилгээ хийх, мэдээллийн сан бүрдүүлж, зохицуулалтаар хангах, аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээ болон байгууллагын стандартыг олон улсын жишигт нийцүүлэх, менежментийг сайжруулах, хэрэгжилтийг хангах талаар нутгийн захиргааны байгууллага, мэргэжлийн байгууллага, аж ахуйн нэгж, олон нийтийн байгууллага, иргэдийг мэргэжил, арга зүйн зөвлөгөөгөөр хангах, аялал жуулчлалын байгууллага, аялал жуулчлалын мэргэжлийн холбооны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, сайд, яамны Төрийн нарийн бичгийн даргад цаг үеэ олсон мэргэшлийн зөвлөгөө, шуурхай мэдээлэл, үйлчилгээ, бүх талын дэмжлэг үзүүлэхэд чиглэгдэнэ.

Энэ нэгжийн үйл ажиллагааны чиг үүрэг нь сайдын эрхлэх асуудлын хүрээний бодлого, хууль тогтоомж, төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах, төрийн захиргааны болон нутгийн захиргааны байгууллага, аялал жуулчлалын байгууллагын хоорондын уялдаа холбоог хангах, мэргэжил, арга зүйн удирдлага, мэдээллээр хангахад чиглэгдэнэ.

Энэ нэгжийн үндсэн үйлчлүүлэгч нь сайд, яамны Төрийн нарийн бичгийн дарга, аялал жуулчлалын холбоод, байгууллага, их, дээд сургууль, эрдэмтэн, судлаач, иргэд байх бөгөөд шууд бус хэрэглэгч нь бусад яам, Засгийн газрын тохируулагч, хэрэгжүүлэгч агентлаг, нутгийн захиргааны байгууллага, төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшил, иргэд байна.

3.3.5. Биеийн тамир, спорт, залуучуудын бодлого зохицуулалтын асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний үндсэн үүрэг, чиг үүрэг:

Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн 5 дугаар зорилтын хүрээнд биеийн тамир, спортын талаарх хууль тогтоомж, бодлого, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенцын хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах, биелэлтийг хангуулах, биеийн тамир, спортын чиглэлээр судалгаа, шинжилгээ хийх, салбарын удирдлага, зохион байгуулалтыг сайжруулах, идэвхтэй хөдөлгөөнөөр хичээллэх дадлыг бий болгох, бие бялдрын боловсрол олгох, эрүүл, идэвхтэй амьдрах соёлыг нийгэмд төлөвшүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах, бие бялдрын түвшин тогтоох сорилын үйлчилгээний чанарын болон гүйцэтгэлийн үнэлгээ хийх, хянах иж бүрэн тогтолцоог бүрдүүлэх, бодлого, зөвлөмж боловсруулах, түгээх, удирдлагаар хангах, спортын төрлийг хөгжүүлэх, шигшээ багийн тамирчдыг бэлтгэх тогтолцоог бэхжүүлж, тамирчдын тив, дэлхий, олимпын түвшинд өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, мэргэжлийн спортыг дэмжих ажлыг зохион байгуулах, үндэсний болон мэргэжлийн спортыг дэмжин хөгжүүлэх, биеийн тамир, спортоор хичээллэх орчин, нөхцөлийг сайжруулж, хүртээмжийг нэмэгдүүлэх, улсын болон олон улсын хэмжээнд зохион байгуулагдах спортын наадам, тэмцээн, арга хэмжээг төлөвлөх, мэргэжил, арга зүйн зөвлөгөөгөөр хангах, залуучуудын хөгжлийг дэмжих талаарх хууль тогтоомж, бодлого, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенцын хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах, биелэлтийг хангуулах, залуучуудын хувь хүний хөгжил болон нийгэм, эдийн засгийн хөгжилд хувь нэмрээ оруулахад шаардлагатай бүх төрлийн дэмжлэг, туслалцааг үзүүлэх, орчин, нөхцөл бүрдүүлэх, залуучуудын хөдөлмөр эрхлэлт, сайн дурын ажлыг дэмжих, оролцоог хангасан таатай нөхцөл бүрдүүлэх үйл ажиллагааг удирдлага арга зүйгээр хангаж, сайд, яамны Төрийн нарийн бичгийн даргад цаг үеэ олсон мэргэшлийн зөвлөгөө, шуурхай мэдээлэл, үйлчилгээ, бүх талын дэмжлэг үзүүлэхэд чиглэгдэнэ.

Энэ нэгжийн үйл ажиллагааны чиг үүрэг нь сайдын эрхлэх асуудлын хүрээний бодлого, хууль тогтоомж, төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах, төрийн захиргааны болон нутгийн захиргааны байгууллага, биеийн тамир, спорт, залуучуудын байгууллагын хоорондын уялдаа холбоог хангах, мэргэжил, арга зүйн удирдлага, мэдээллээр хангахад чиглэгдэнэ.

Энэ нэгжийн үндсэн үйлчлүүлэгч нь сайд, яамны Төрийн нарийн бичгийн дарга, спортын холбоод, их, дээд сургууль, эрдэмтэн, судлаач, иргэд байх бөгөөд шууд бус хэрэглэгч нь бусад яам, Засгийн газрын тохируулагч, хэрэгжүүлэгч агентлаг, нутгийн захиргааны байгууллага, төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшил, иргэд байна.

3.3.6. Санхүү, хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний үндсэн үүрэг, чиг үүрэг:

Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн 6 дугаар зорилтын хүрээнд соёлын салбарын төсвийн жил бүрийн төлөвлөлтийг оновчтой боловсруулах, хэрэгжилтийг удирдлага, зохион байгуулалтаар хангах, эдийн засгийн үр ашгийн шинжилгээ хийх, салбарын харьяа байгууллагын төсвийг нэгтгэн боловсруулах, хэрэгжилтийг зохион байгуулах, төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн сар, улирлын болон хөтөлбөр, арга хэмжээний хуваарилалт хийх, захиран зарцуулах, тайлагнах ажлыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах, зохицуулалтаар хангах, мэдээллийн сан бүрдүүлэх, төсвийг ил тод мэдээлэх, төрийн сангийн үйл ажиллагаа эрхлэх, соёлын салбарын хөрөнгө оруулалт, үйлдвэрлэлийн жил бүрийн төсвийн төлөвлөлтийг оновчтой боловсруулах, хэрэгжилтийг удирдлага, зохион байгуулалтаар хангах, салбарын хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын төсөл хэрэгжүүлэх, хөрөнгө оруулалтын гүйцэтгэлд аудит хийлгэх, худалдан

авалтыг зохион байгуулах, хөрөнгө оруулалтын мэдээллийн цахим сан бүрдүүлэх, шинжилгээ хийх, мэдээллээр хангах, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах, хөгжүүлэх үндсэн үүрэг хүлээж ажиллана.

Энэ нэгжийн үйл ажиллагааны чиг үүрэг нь сайдын эрхлэх асуудлын хүрээний соёлын салбарын бодлого, үйл ажиллагааны эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх, төсвийн ерөнхийлөн захирагчийн жил бүрийн төсвийн төсөл, төсөөллийг үндэслэл сайтай боловсруулах, батлуулах, төсвийн зардлыг санхүүжүүлэх, санхүүгийн тайлан, мэдээ гаргах, холбогдох хууль тогтоомжийн дагуу төсвийн гүйцэтгэлд аудит хийлгэх, төсвийн зардлыг нийтэд ил тод мэдээлэх, санхүүжилтийн механизмыг боловсронгуй болгох ажлыг зохицуулна.

Энэ нэгжийн үндсэн үйлчлүүлэгч нь сайд, яамны Төрийн нарийн бичгийн дарга, зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд, дотоод аудитор, Сангийн яам, Засгийн газрын тусгай сан, соёл, урлагийн байгууллага, эрдэмтэн, судлаач, иргэд байх бөгөөд шууд бус хэрэглэгч нь бусад яамд, нутгийн захиргааны байгууллага, соёл, урлагийн байгууллага, төрийн болон төрийн бус байгууллага байна.

3.3.7.Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний үндсэн үүрэг, чиг үүрэг:

Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн 7 дугаар зорилтын хүрээнд салбарын хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, төлөвлөгөө, төслийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх, үнэлгээ өгөх, дүгнэлт гарах, зөвлөмж өгөх, салбарын болон яамны санхүүгийн үйл ажиллагаанд эрсдэлийн үнэлгээ хийх, дотоод аудит хийх, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, салбарын эрсдэлд суурилсан хяналт шалгалтын бодлогыг хэрэгжүүлэх, эрсдэлийн шалгуур үзүүлэлт, хяналт шалгалт явуулахтай холбогдсон дүрэм, журам, заавар, аргачлал, хяналтын хуудсыг боловсруулан батлуулах, эрсдэлийн үнэлгээ хийх, хяналт шалгалтыг эрсдэлд суурилан төлөвлөн хэрэгжүүлэх, зөрчлийг шалган шийдвэрлэх, хяналт шалгалтын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санг хөтлөх, эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр тандалт судалгаа, дүн шинжилгээ хийх үндсэн үүрэг хүлээж ажиллана.

Энэ нэгжийн үйл ажиллагааны чиг үүрэг нь салбарын хөгжлийн бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилт, төсөв, төсөл, хөтөлбөрийн явц, үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит, эрсдэлийн үнэлгээ хийж, салбарын хяналт шалгалтыг бусад салбарын хяналтын үйл ажиллагаатай уялдуулан хэрэгжүүлж, зөрчлийг шалган шийдвэрлэн, акт, дүгнэлт, зөвлөмж гарган, хэрэгжилтийг хангуулах, соёл, урлагийн салбарт үүсэж болзошгүй аюул, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоож иргэдийг чанартай, хүртээмжтэй соёлын ажил, үйлчилгээ хүртэхэд дэмжлэг үзүүлэхэд чиглэгдэнэ.

Энэ нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь сайд, яамны Төрийн нарийн бичгийн дарга, зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд, албан хаагчид, салбарын байгууллага, аж ахуйн нэгж байх бөгөөд шууд бус хэрэглэгч нь яамд, Засгийн газрын агентлаг, нутгийн захиргааны байгууллага, бусад хэрэглэгч байна. Энэ үйлчилгээг үзүүлэхэд оролцох гол түнш нь Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, яамд, төрийн болон төрийн бус байгууллага, иргэд байна.

